

УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ
БАЙДЛЫН ТОЙМ /2025 ОНЫ 05 ДУГААР САР/


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 19 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг тасралтгүй хэмжилтийн автомат багажаар тодорхойлж байна.

Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе 2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад азотын давхар исэл (NO₂) нь 11 мкг/м³-ээр буюу 30 %-иар, хүхэрлэг хий (SO₂) нь 2 мкг/м³-ээр буюу 13 %-иар бага, харин PM2.5 тоосонцор 2 мкг/м³-ээр буюу 17%-иар, PM10 тоосонцор 11 мкг/м³-ээр буюу 18 %-иар их байна.


Хүснэгт 1. Агаар дахь бохирдуулах бодисын 2024, 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламж

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Сарын дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2024 оны 05 дугаар сар	2025 оны 05 дугаар сар
Азотын давхар исэл, NO ₂	50	36	25
Хүхэрлэг хий, SO ₂	50	15	13
PM2.5 тоосонцор	50	12	14
PM10 тоосонцор	100	62	73

Улаанбаатар хотын 2025 оны 05 дугаар сарын агаар бохирдуулах гол бохирдуулагч бодис тус бүрийн сарын дундаж агууламжийг дараах зурагт харууллаа. (Зураг 1- 9)




Зураг 1. 2024, 2025 оны 05 дугаар сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламж

PM2.5 тоосонцор

Зураг 2. PM2.5 тоосонцрын 05 дугаар сарын агууламж, 2021-2025 он


Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай ижил түвшинд, 2022-2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2 мкг/м³-ээр буюу 17 %-иар их байна. (Зураг 2).



Зураг 3. PM2.5 тоосонцрын 05 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр


2025 оны 05 дугаар сарын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж Мишээл экспо 15 мкг/м³, 100-н айл 9 мкг/м³, Цахилгаан станц 24 мкг/м³, Ургах наран хороолол 16 мкг/м³, Зайсан 4 мкг/м³ байна.

2024 оны 05 дугаар сартай харьцуулахад Бөхийн өргөө 2 мкг/м³-ээр, Нисэх 1 мкг/м³-ээр тус тус бага. Баруун 4-н зам 1 мкг/м³-ээр, 1-р хороолол 8 мкг/м³-ээр, Шархад 2 мкг/м³-ээр, Налайх 8 мкг/м³-ээр, Яармаг 3 мкг/м³-ээр, Толгойт 3 мкг/м³-ээр, Баянхошуу 1 мкг/м³-ээр, Дамбадаржаа 3 мкг/м³-ээр тус тус их, харин Хайлааст, Зурагт ижил түвшинд байсан байна. (Зураг 3).

PM10 тоосонцор

Зураг 4. PM10 тоосонцрын 2021-2025 оны 05 дугаар сарын дундаж агууламж


PM10 тоосонцрын 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 17 мкг/м³-ээр буюу 30%-иар их, 2022 оны 05 дугаар сарын дундаж агууламжаас 4 мкг/м³-ээр буюу 5 %-иар бага, харин 2023-2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжаас 11-18 мкг/м³-ээр буюу 18-33 %-иар их байна (Зураг 4).



Зураг 5. PM10 тоосонцрын 05 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр


2025 оны 05 дугаар сарын PM10 тоосонцрын дундаж агууламж Цахилгаан станц 215 мкг/м³, 5-н буудал 113 мкг/м³ байна.

2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад Мишээл экспо 6 мкг/м³-ээр, Баруун 4-н зам 9 мкг/м³-ээр, Бөхийн өргөө 25 мкг/м³-ээр, 100-н айл 14 мкг/м³-ээр, Хайлааст 5 мкг/м³-ээр, Зайсан 8 мкг/м³-ээр, Налайх 6 мкг/м³-ээр, Нисэх 6 мкг/м³-ээр, Зурагт 9 мкг/м³-ээр тус тус бага. Харин 1-р хороолол 15 мкг/м³-ээр, Ургах наран хороолол 16 мкг/м³-ээр, Шархад 4 мкг/м³-ээр, Яармаг 17 мкг/м³-ээр, Толгойт 31 мкг/м³-ээр, Дамбадаржаа 7 мкг/м³-ээр тус тус их байна (Зураг 5).

Азотын давхар исэл (NO_2)

Зураг 6. Азотын давхар ислийн 05 дугаар сарын дундаж агууламж, 2021-2025 он


Азотын давхар ислийн (NO_2) 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламж 2021 оны 05 дугаар сараас 1 мкг/м³-ээр буюу 4 %-иар их. Харин 2022-2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 4-11 мкг/м³-ээр буюу 14-30%-иар бага байна (Зураг 6).



Зураг 7. Азотын давхар ислийн 05 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр


2025 оны 05 дугаар сарын Азотын давхар исэл (NO_2)-ийн дундаж агууламж Мишээл экспо 6 мкг/м³, Цахилгаан станц 17 мкг/м³, 5-н буудал 19 мкг/м³ байна.

2024 оны 05 дугаар сартай харьцуулахад Баруун 4-н зам 106 мкг/м³-ээр, 100-н айл 2 мкг/м³-ээр, Шархад 6 мкг/м³-ээр, Налайх 8 мкг/м³-ээр, Толгойт 2 мкг/м³-ээр, Зурагт 10 мкг/м³-ээр тус тус бага. Ургах наран хороолол 3 мкг/м³-ээр, Хайлааст 2 мкг/м³-ээр, Зайсан 4 мкг/м³-ээр, Яармаг 4 мкг/м³ тус тус их, харин Бөхийн өргөө ижил түвшинд байна (Зураг 7).

Хүхэрлэг хий (SO_2)

Зураг 8. Хүхэрлэг хийн 2021-2025 оны 05 дугаар сарын дундаж агууламж



Хүхэрлэг хийн (SO_2) 2025 оны 05 дугаар сарын дундаж агууламжийг 2021-2024 оны 05 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2-6 мкг/м³-ээр буюу 13-31 %-иар бага байна (Зураг 8).





Зураг 9. Хүхэрлэг хийн 05 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр

2025 оны 05 дугаар сард хүхэрлэг хий (SO_2)-н дундаж агууламж Цахилгаан станц 9 мкг/м³, 5-н буудал 13 мкг/м³, Баянхошуу 10 мкг/м³ байна.

2024 оны 05 дугаар сартай харьцуулахад Мишээл экспо 12 мкг/м³-ээр, 1-р хороолол 13 мкг/м³-ээр, 100-н айл 1 мкг/м³-ээр, Хайлааст 6 мкг/м³-ээр, Шархад 9 мкг/м³-ээр, Налайх 2 мкг/м³-ээр, Толгойт 4 мкг/м³-ээр тус тус бага. Баруун 4-н зам 5 мкг/м³-ээр, Ургах наран хороолол 1 мкг/м³-ээр, Зайсан 12 мкг/м³-ээр, Яармаг 7 мкг/м³ тус тус их, харин Бөхийн өргөө ижил түвшинд байна (Зураг 9).





**УЛААНБААТАР ХОТЫН 2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН
ЦАГ АГААРЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ /2024 ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАВ/**

№	Цаг уурын үзүүлэлт	2024 оны 05 дугаар сар	2025 оны 05 дугаар сар
1	Агаарын дундаж температур °C	12.8 °C	10.9 °C
2	Салхины дундаж хурд, м/с	2.6 м/с	2.8 м/с
3	Сарын нийлбэр хур тунадас, мм	25 мм	10.3 мм

**2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН АГААРЫН ЧАНАРЫН ИНДЕКСИЙН МЭДЭЭ,
/АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРУУЛ ТУС БҮРЭЭР/**

1-р хороолол May-25							100-н айл May-25							Толгойт May-25							Нисэх May-25						
Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su
			1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4
5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31	

Зурагт May-25							Дамбадаржаа May-25							Баянхошуу May-25							Хайлааст May-25						
Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su
			1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4
5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31	

5-н буудал May-25							Шархад May-25							Налайх May-25							13-р хороолол May-25						
Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su
			1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4
5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31	

Баруун 4-н зам May-25							Амгалан May-25							Цахилгаан станц May-25							Мишээл экспо May-25						
Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su
			1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4
5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31	

Зайсан May-25							Ургах наран хороолол May-25							Яармаг May-25							
Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	Mo	Tu	We	Th	Fr	Sa	Su	
			1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4	
5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	5	6	7	8	9	10	11	
12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	12	13	14	15	16	17	18	
19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	19	20	21	22	23	24	25	
26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		26	27	28	29	30	31		

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**


ХҮЙТНИЙ УЛИРАЛ БУЮУ 2024 ОНЫ 10-12, 2025 ОНЫ 1-4 ДҮГЭЭР САР

Хүйтний улирал буюу 2024 оны 10-12 сар, 2025 оны 1-4 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг өмнөх онуудын мөн үе 2023 оны 10-12 сар, 2024 оны 1-4 дүгээр сарын дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор нь 10 мкг/м³ буюу 16%-иар, азотын давхар исэл (NO₂) нь 6 мкг/м³-ээр буюу 11%-иар, хүхэрлэг хий (SO₂) нь 13 мкг/м³-ээр буюу 16%-иар тус тус бага. Харин PM10 тоосонцор нь 5 мкг/м³-ээр буюу 5%-иар их байна.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м³	
	Хүлцэх агууламж, мкг/м³	2023 оны 10-12-р сар, 2024 оны 1-4-р сарын дундаж	2024 оны 10-12-р сар, 2025 оны 1-4-р сарын дундаж
PM2.5 тоосонцор	50	63	53
Азотын давхар исэл, NO₂	50	53	47
PM10 тоосонцор	100	101	106
Хүхэрлэг хий, SO₂	50	81	68


Агаар дахь бохирдуулах бодисуудын агууламжийн өөрчлөлтийг зураг 1-8-д доорх байдлаар харуулав.

PM2.5 тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2025 он


2024 оны 10-12, 2025 оны 1-4 дүгээр сарын PM2.5 тоосонцрын дундаж агууламжийг өмнөх онуудтай харьцуулахад 2018-2019 оноос 54 мкг/м³-ээр буюу 50%-иар бага, 2019-2020 оноос 11 мкг/м³-ээр буюу 17%-иар бага, 2020-2021 оноос 7 мкг/м³-ээр буюу 12%-иар бага, 2021-2022 оноос 12 мкг/м³-ээр буюу 18%-иар бага, 2022-2023 оноос 8 мкг/м³-ээр 13 %-иар бага, 2023-2024 оноос 10 мкг/м³-ээр 16%-иар бага байна.



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2021-2025 он


2024-2025 оны хүйтний улиралд агаар дахь PM2.5 тоосонцрын сарын дундаж хамгийн их агууламж 2024 оны 12 дугаар сард 99 мкг/м³ байсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын дундажтай харьцуулахад 1 мкг/м³-ээр буюу 1 %-иар их байна (Зураг 2).

Азотын давхар исэл (NO₂)



Зураг 3. Азотын давхар ислийн хүйтний улирлын дундаж агууламж, 2018-2025 он


2024 оны 10-12, 2025 оны 1-4 дүгээр сарын азотын давхар ислийн (NO₂) дундаж агууламжийг өмнөх онуудтай харьцуулахад 2018-2019 оноос 4 мкг/м³-ээр буюу 9%-иар их, 2019-2020 оноос 5 мкг/м³-ээр буюу 10%-иар бага, 2020-2021 оноос 5 мкг/м³-ээр буюу 12%-иар их, 2021-2022 оноос 4 мкг/м³-ээр буюу 8%-иар бага, 2022-2023 оноос 3 мкг/м³-ээр 6 %-иар бага, 2023-2024 оноос 6 мкг/м³-ээр 11%-иар бага байна. (Зураг 3).



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2021-2025 он


2024-2025 оны хүйтний улиралд агаар дахь азотын давхар ислийн (NO_2) хамгийн их агууламж 2024 оны 12 дугаар сард 57 мкг/м^3 байсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын дундажтай харьцуулахад 7 мкг/м^3 -ээр буюу 11 %-иар бага байна (Зураг 4).

PM10 тоосонцор



Зураг 5. Хүйтний улирлын PM10 тоосонцрын дундаж агууламж, 2018-2025 он


2024 оны 10-12, 2025 оны 1-4 дүгээр сарын PM10 тоосонцрын дундаж агууламжийг өмнөх онуудтай харьцуулахад 2018-2019 оноос 78 мкг/м^3 -ээр буюу 42%-иар бага, 2019-2020 оноос 6 мкг/м^3 -ээр буюу 5%-иар бага, 2020-2021 оноос 1 мкг/м^3 -ээр буюу 1%-иар бага, 2021-2022 оноос 16 мкг/м^3 -ээр буюу 13%-иар бага, 2022-2023 оноос 1 мкг/м^3 -ээр 1 %-иар бага, харин 2023-2024 оноос 5 мкг/м^3 -ээр 5 %-иар их байна (Зураг 5).



Зураг 6. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2021-2025 он


2024-2025 оны хүйтний улиралд агаар дахь PM10 тоосонцрын хамгийн их агууламж 2024 оны 12 дугаар сард 131 мкг/м^3 байсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын дундажтай харьцуулахад 15 мкг/м^3 -ээр буюу 13 %-иар их байна (Зураг 6).

Хүхэрлэг хий (SO_2)



Зураг 7. Хүйтний улирлын хүхэрлэг хийн дундаж агууламж, 2018-2025 он

2024 оны 10-12, 2025 оны 1-4 дүгээр сарын хүхэрлэг хийн (SO_2) дундаж агууламжийг өмнөх онуудтай харьцуулахад 2018-2019 оноос 32 мкг/м^3 -ээр буюу 89%-иар их, 2019-2020 оноос 3 мкг/м^3 -ээр буюу 5%-иар их, 2020-2021 оноос 44 мкг/м^3 -ээр буюу 39%-иар бага, 2021-2022 оноос 32 мкг/м^3 -ээр буюу 32%-иар бага, 2022-2023 оноос 23 мкг/м^3 -ээр 25 %-иар бага, 2023-2024 оноос 13 мкг/м^3 -ээр 16%-иар бага байна. (Зураг 7).



Зураг 8. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2021-2025 он

2024-2025 оны хүйтний улиралд агаар дахь хүхэрлэг хийн (SO_2) хамгийн их агууламж 2025 оны 01 дүгээр сард 124 мкг/м^3 байсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын дундажтай харьцуулахад 28 мкг/м^3 -ээр буюу 18 %-иар бага байна. (Зураг 8)

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС